



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Ахлах сургууль байгуулах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.5 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2 дахь заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн Лицей сургуулийг 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс “Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургууль” болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн үйл ажиллагааг хууль, дүрэм журамд нийцүүлэн зохион байгуулж явуулахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2021 оны үйл ажиллагааны орлогын төсвийг 62,262,491,700.0 /жаран хоёр тэрбум хоёр зуун жаран хоёр сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга долоон зуун/ төгрөгөөр тогтоож нэгдүгээр хавсралтаар, зарлагын төсвийг 61,782,452,200.0 /жаран нэгэн тэрбум долоон зуун наян хоёр сая дөрвөн зуун тавин хоёр мянга хоёр зуун/ төгрөгөөр тогтоож хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 3,879,700.0 /гурван тэрбум найман зуун далан есөн сая долоон зуун мянга/ төгрөгөөр тогтоож гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу захиран зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНБАЯР





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны чиглэл өгөх тухай

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.7.5 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021 оны төсөвт тусгагдсан орлогоос гадна бусад үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх боломжийг судалж, үр дүнг 2021 оны нэгдүгээр улиралд багтаан Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлд танилцуулахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР